БАТЛАВ:

ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР ТӨҮГ-Н

ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНИКИЙН БОДЛОГЫН

ГАЗАРЫН ДАРГА

……П.БАТБОЛОР

2025оны 06 сарын 26 өдөр

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

(ӨРМИЙН ТӨХӨӨРӨМЖҮҮДИЙН ЗАСВАР, СЕРВИС ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛ)

1. **ЗАХИАЛАГЧ:** ГЕОЛОГИ ХАЙГУУЛЫН ЭКСПЕДИЦИ
2. **ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТОДОРХОЙЛОЛТ:**

-SH-9000 маркийн өрмийн төхөөрөмж. Бүртгэлийн дугаар №42-80183

-SH-9000 маркийн өрмийн төхөөрөмж. Бүртгэлийн дугаар №42-80200

-SH-9000 маркийн өрмийн төхөөрөмж. Бүртгэлийн дугаар №42-80229

-SH-12000 маркийн өрмийн төхөөрөмж. Бүртгэлийн дугаар №42-82851

-CWD900 маркийн өрмийн төхөөрөмж. Бүртгэлийн дугаар №42-80228

-YJ900 маркийн өрмийн төхөөрөмж. Бүртгэлийн дугаар №42-19161

3. **ЗАСВАР, СЕРВИС ҮЙЛЧИЛГЭЭ ХИЙХ НӨХЦӨЛ ШААРДЛАГА:**

- Техник эдийн засгийн үзүүлэлтүүдийг зохих түвшинд хүргэх зорилгоор засвар үйлчилгээг жил болгон ижил давтамжтайгаар хийдэг.
- Үндсэн тоног төхөөрөмжийн тасралтгүй найдвартай ажиллагааг хангахын тулд засвар, сервис үйлчилгээг хийх шаардлагатай. / Дизель хөдөлгүүр, өрмийн төхөөрөмжийн цамхаг, эргүүлэгч, гидросистем болон гидронасос, шаврын насосуудад үзлэг оношилгоо, үйлчилгээ хийх/.

4. **ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ХЭМЖЭЭ, АЖИЛБАРУУД:**

- Дизель хөдөлгүүр / Engine DOOSAN DE12T/-т оношилгоо , тохиргоо хийх, түлшний систем, аппаратур форсункийг сэргээн засварлаж тохиргоо хийх, масло болон түлшний шүүрнүүдийг солих, клапан тохируулж, тосолгооны системийн хэвийн ажиллагааг хангах;
- Явах ангийн үзлэг тохиргоо, тосолгоо, чангалгаа хийх, гинжний башмак пальцыг шалгаж хэсэгчлэн солих;
- Гидросистем, гидронасоснуудын даралтыг хэмжих, гидрошингэний банкийг цэвэрлэж шүүрнүүд болон шлангуудыг шалгаж, засварлах, гидро хуваарилагчуудын холбох хэсгийн гидрошингэн гоожилт болон хөлөрсөн эсэхийг оношлох, тохируулах, шинээр солих;
- FMC-1122, FMC L1618 ус шаврын насоснуудад үзлэг оношилгоо хийнэ. Ус, шаврын насосны шатун, поршень, гильза, клапанд үзлэг хийх, шинээр солих;

- Өрмийн төхөөрөмжийн цамхагт үзлэг, үйлчилгээ, гулзайлт, хазайлт, цилиндрийн өргөх чадал, гинжний суналтыг шалгах, ролик, пальц шинээр солих, замыг цэвэрлэж тосолгоо хийх;
- Эргүүлэгчийн үзлэг тохиргоо хийнэ. Эргэлт, гидросистемийн даралтыг хэмжих, арааныyд, холхивчны элэгдэл, голны гулзайлт, элэгдлийг тодорхойлж тохиргоо хийнэ. Сальникуудыг шинээр солих;
- Засвар бүрийн дараа комисс гарч шалгалт хийх;

5. **ГҮЙЦЭТГЭГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА:** Засварын ажлыг уул уурхайн хүнд механизм, тоног төхөөрөмжийн засварын ажлыг гүйцэтгэдэг, мэргэжлийн боловсон хүчний чадавхтай (механикч 1, тоног төхөөрөмжийн засварчин 2), гурваас доошгуй жилийн туршлагатай компани гүйцэтгэх;

-Засвар, сервис үйлчилгээний ажлыг жагсаалтын дагуу хийх. Хавсралт №1.

6. **АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА:** Гэрээ байгуулагдсан өдрөөс хойш гэрээнд заасан хугацаанд улиралд нэг удаа хийж гүйцэтгэх.

7. **АЖЛЫН ГЭРЭЭ:** 1 жилийн хугацаатай байгуулах.

8. **ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ:** Батлагдсан төсвийн дагуу төлбөрийг хийх.

9. **АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧИЙН БАТАЛГАА**: SH-12000-1ш SH-9000-3ш, CWD-900, YJ-900 маркийн өрмийн төхөөрөмжүүдэд сервис үйлчилгээ хийж ажилд орсон өдрөөс 90 хоногийн баталгааг АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧ гаргах.

ЗӨВШӨӨРСӨН:

МХ-ИЙН ДАРГА, ЕРӨНХИЙ МЕХАНИКЧ Б.ЧИНЗОРИГ

ХЯНАСАН:

ГХЭ-ИЙН ДАРГА М.ДАМДИНСҮРЭН

БОЛОВСРУУЛСАН:

ГХЭ-ИЙН МЕХАНИКЧ Х.ЭРДЭНЭБИЛЭГ

Хавсралт №1

ӨРМИЙН ТӨХӨӨРӨМЖҮҮДЭД ХИЙГДЭХ ЗАСВАР, СЕРВИС ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ЖАГСААЛТ

№	**SUNGHAN 9000, 12000 МАРКИЙН 4, CWD 9000, YJ 900 өрмийн төхөөрөмжүүдэд хийгдэх ажлын жагсаалт**
I	**Өрмийн төхөөрөмжийн цамхагын үзлэг, тохиргоо, засвар**
1	Цамхагны тулгуур шалгах
2	Цамхагны хазайлт, гулзайлт шалгах
3	Цамхагны түгжээг шалгах, засварлах
4	Цамхагны роликуудыг шалгах, засварлах, шинээр солих
5	Цамхагны төв цилиндрийн өргөх хүчин чадлыг хэмжих, тохируулах
6	Өрөмдлөгийн явц дахь цамхагны төв цилиндэрт өгөх даралтыг хэмжих, тохируулах
7	Цамхагны гинжнүүд сунасан, тунарсан бол тэнцүүлэх, чангалах хасах, нэмэх, пальцуудыг шалгах, хавтаснуудыг солих
8	Цамхагны гинжний роликуудыг шинээр солих
9	Цамхагны толгойн болон гинжний роликуудын цэгэн тосолгоо хийх, маслянкуудыг солих
10	Цамхагны төв цилиндрийн хэвийн ажиллагааг хангах, сальникийг шинээр солих
11	Цамхагыг босгож буулгах цилиндрийн хэвийн ажиллагааг хангах, сальникийг шинээр солих
12	Цамхагны хавтасны замыг шалгах, зам цоорсон сэтэрсэн, хазайсан бол солих
13	Цамхагийг дагасан шлангуудын эвхэгддэг зам, түүний хөндлөн пальцуудыг шалгах, солих
II	**Өрмийн төхөөрөмжийн эргүүлэгчийн үзлэг, тохиргоо, засвар**
14	Эргүүлэгчийн эргэлтийн хурд хэмжих, тохиргоо хийх
15	Эргүүлэгчиийн гидрошингэний даралтыг хэмжих, тохируулах
16	Хурдан болон хүндрүүлэгч гидромоторын эргэлтийн хурд, даралт, мушгих хүчин чадлыг хэмжих, тохиргоо хийх
17	Хурдан эргэлтийн гидромоторын хөтлөгч болон шилжүүлэгч араануудын элэгдлийг хэмжих
18	Хурдан эргэлтийн гидромоторын сальникийг шинээр солих
19	Хүндрүүлэгч гидромоторын хөтлөгч болон шилжүүлэгч араануудын элэгдлийг хэмжих
20	Удаан эргэлтийн гидромоторын сальникийг шинээр солих
21	Хурдны хайрцгийн эргэлт хурднаас удаанд, удаанаас хурданд хэвийн шилжиж байгаа эсэхийг шалгах, тохиргоо хийх
22	Хүндрүүлэгч гидромоторын арааг салгаж нийлүүлдэг цилиндрийн ажиллагаа, арааг салгаж нийлүүлдэг сэрээг шалгах, тохиргоо хийх, цилиндрийн сальник шинээр солих
23	Хурдан эргэлтийн болон хүндрүүлэгч гидромоторын холхивчуудыг солих, цэгэн тосолгоо хийх
24	Эргүүлэгчийн ноён арааны элэгдлийг шалгаж шаардлагатай бол солих
25	Эргүүлэгчийн голны гулзайлт байгаа эсэхийг задалж шалгах, шлицний элэгдлийг хэмжих
26	Эргүүлэгчийн голны том холхивчуудыг шаардлагатай бол солих
27	Эргүүлэгчийн сальникуудыг шинээр солих
28	Эргүүлэгчийн тосыг солих
29	Эргүүлэгчийн тосолгооны насосыг шинээр солих

30	Тосолгооны сувгуудыг цэвэрлэх
31	Эргүүлэгчийн хөндлөн явагчийн цилиндрийн тохиргоо хийх, сальникууд шинээр солих
32	Эргүүлэгчийн голны сул явалтыг тохируулах
33	Усны цутгалангийн холхивч, голыг шалгах, сальникуудыг шинээр солих
34	PQ, HQ,NQ sub-ийг шалгаж элэгдсэн тохиолдолд солих
35	Эргүүлэгчний голны эргэлт тоологч буюу эргэлтийн хурд хэмжигчийг тохируулах
III	**Өрмийн төхөөрөмжийн DE12T дизель хөдөлгүүрийн үзлэг, техник үйлчилгээ буюу ерөнхий байдалд үзлэг хийх**
36	Дизель хөдөлгүүрт нам болон өндөр даралт өгч хэвийн ажиллагааг шалгах, компьютер оношилгоо хийх
37	Моторын эргэлтийн, даралтын, усны, түлшний, амперметрийн датчикуудыг шинээр солих
38	Аппаратурын тохиргоо хийх
39	Форсункууд, түлш, тосны насосны хэвийн ажиллагааг шалгах, тохиргоо хийх
40	Стартер, жанам, ременүүд шинээр солих
41	Тосны даралт, усны температур, моторын эргэлт, түлш хэмжигч мэдрэгч(sensor) шинээр солих
42	Тосны шүүр, түлшний шүүр, агаар шүүгч, агаар шүүгчин хоолой шинээр солих
43	Аваарын болон албадан унтраалга шинээр солих
IV	**Өрмийн төхөөрөмжийн явах ангийн үзлэг оношилгоо, тохирго, тосолгоо хийх**
44	Гинжний элэгдэл, суналт зэргэд үзлэг хийж шаардлагатай башмакийг солих, башмакны пальц солих
45	Гинжийг тэнцүүлж чангалах
46	Одон дугуй явах ангийн гидромотор хоорондын боолтуудыг чангалах, сальникуудыг солих
47	Каткинуудын элэгдлийг тодорхойлох
48	Явах ангийн гидромоторуудын мушгих хүчин чадлыг хэмжих, хурд, хүчийг тэнцүүлэх, тохируулах
49	Явах ангийн бүх деталуудад цэгэн тосолгоо хийх
V	**Өрмийн төхөөрөмжийн гидросистемийн болон насоснуудад засвар, үйлчилгээ, үзлэг оношилгоо хийх**
50	Ажлын өргөх эргүүлгийн гидромоторын өргөх хүч, эргэлтийн хурд зэргийг хэмжиж, тохируулах
51	Ажлын өргөх эргүүлгийн дамарын холхивчийг шалгах
52	Дээжний өргөх эргүүлгийн гидромоторын татах хүч, хурдыг хэмжих, тохируулах
53	Дээжний өргөх эргүүлгийн троссны элэгдлийг тодорхойлох
54	Дээжний өргөх эргүүлгийн дамарын холхивчийг шинээр солих
55	Гидрошингэний бак цоорсон, хөлөрсөн эсэхийг шалгаж битүүмжлэлийг хангах
56	Гидрошингэний зунгаг чанар, тослогийн хэмжээг тодорхойлох шинээр солих
57	Өрмийн төхөөрөмжийн хянах самбарын бүрэн бүтэн байдлыг хангах, манометрүүд болон бусад мэдрэгчүүдийг шинээр солих
58	Хуваарилагчуудын рычаг болон хаалтуудыг шинээр солих
59	Гидросистемийн хуваарилагчуудын холбох хэсгээр гидрошингэн гоожиж, хөлөрч, байгаа эсэхийг шалгаж, жийргэвч нэмэх, чангалгаа хийх
60	Өрмийн төхөөрөмжийг ачих, буулгах, газрын хэвгийд тэгшлэх, градустай өрөмдлөгт тааруулах зориулалт бүхий домкратны цилиндрүүдийн хэвийн ажиллагааг хангах

61	Домкратнуудын хөлний хазайлт, тахийлт, боолтуудыг шалгаж засварлах, тэгшлэх, шинээр солих
62	Домкратны үл буцах клапангуудын хэвийн ажиллагааг хангах, шинээр солих
63	Сум баригчийн цилиндрийн сальникийг шинээр солих
VI	**Өрмийн төхөөрөмжийн FMC-1122, FMC L1618 шаврын насоснуудад засвар, үйлчилгээ, үзлэг оношилгоо хийх**
64	Шаврын насосны редукторыг задлаж холхивч, тахир гол, шилжүүлэгч араа, шатун, поршень зэрэгт үзлэг, тохиргоо хийх, шинээр солих
65	Шаврын насосны редукторын тосыг солих
66	Шаврын насосны плунжерийн манжет, гильз, том, жижиг титэм, шток, сальникийг шинээр солих

ЗӨВШӨӨРСӨН:

МХ-ИЙН ДАРГА, ЕРӨНХИЙ МЕХАНИКЧ Б.ЧИНЗОРИГ

ХЯНАСАН:

ГХЭ-ИЙН ДАРГА М.ДАМДИНСҮРЭН

БОЛОВСРУУЛСАН:

ГХЭ-ИЙН МЕХАНИКЧ Х.ЭРДЭНЭБИЛЭГ

Хавсралт №2

ӨРМИЙН ТӨХӨӨРӨМЖҮҮДЭД ЗАСВАР, СЕРВИС ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮЕД ШИНЭЭР СОЛИХ СЭЛБЭГ, МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

№	Сэлбэгийн нэр	Нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Тосны даралтын датчик	Ш	4	285,000	1,140,000
2	Усны температурын датчик	Ш	4	285,000	1,140,000
3	Моторын эргэлтийн датчик	Ш	4	285,000	1,140,000
4	Түлшний датчик	Ш	4	285,000	1,140,000
5	Амперметрийн датчик	Ш	4	275,000	1,100,000
6	Тосны даралт хэмжигчийн мэдрэгч /sensor/	Ш	4	365,000	1,460,000
7	Усны температур хэмжигчийн мэдрэгч /sen/	Ш	4	365,000	1,460,000
8	Моторын эргэлт хэмжигчийн мэдрэгч /sen/	Ш	4	365,000	1,460,000
9	Түлш хэмжигчийн мэдрэгч /sensor/	Ш	4	365,000	1,460,000
10	Сальникууд	Ш	20	185,000	3,700,000
11	Аваарын унтраалга	Ш	6	154,700	928,200
12	Албадан унтраалга	Ш	6	275,000	1,650,000
13	Динам генератор	Ш	3	1,425,000	4,275,000
14	Стартер	Ш	3	4,250,000	12,750,000
15	Ремень	Ш	4	185,400	741,600
16	Хавтасны холхивч	Ш	20	295,000	5,900,000
17	Хурдны хайрцагны домбон холхивч	Ш	16	475,000	7,600,000
18	Хурдны хайрцагны үрлэн холхивч	Ш	16	475,000	7,600,000
19	Морин толгойн дамарны холхивч	Ш	12	276,000	3,312,000
20	Гинжний дамарны холхивч	Ш	12	365,000	4,380,000
21	Тосолгооны насос	Ш	8	625000	5,000,000
22	Төв цилиндрийн сальник	Ком	8	275000	2,200,000
23	Эрүүг өргөх цилиндрийн сальник	Ком	4	165550	662,200
24	Хурдны хайрцагны хөндлөн цилиндрийн сальник	Ш	4	62500	250,000
25	Цамхагыг босгож, буулгах цилиндрийн сальник	Ком	8	150000	1,200,000
26	4 домкратны цилиндрийн сальник	Ком	16	155000	2,480,000
27	4 домкратны хөндлөн цилиндрийн сальник	Ком	16	75000	1,200,000
28	Сум баригчийн цилиндрийн сальник	Ш	8	35000	280,000
29	Сум тайлагчийн цилиндрийн сальник	Ш	8	35000	280,000
30	Эргүүлэгчийн голны сальник	Ш	12	180500	2,166,000
31	Гидрийн буцахын цаасан шүүр	Ш	12	275,600	3,307,200
32	Гидрийн сорохын төмөр шүүр	Ш	12	325,000	3,900,000
33	Түлшний шүүр	Ш	8	145,500	1,164,000
34	Маслын шүүр	Ш	8	175,500	1,404,000
35	Үл буцах клапангууд	Ш	24	265,000	6,360,000

36	Даралт тохируулагч крантууд	Ш	16	275000	4,400,000
37	О-ринг комплект	Ш	2	165,000	330,000
38	Морин толгойны ролик	Ш	12	575,000	6,900,000
39	Гинжний ролик	Ш	12	675,000	8,100,000
40	Товуд, маслянка	ком	1	165,000	165,000
41	Өрмийн агаар шүүгч	Ш	12	285,000	3,420,000
42	Агаар шүүгчийн хоолой	Ш	6	85,000	510,000
43	Гидрийн сорохын хоолой	Ш	6	85,000	510,000
44	Гидрийн эрвээхэй хаалт	Ш	6	285,000	1,710,000
45	Ажил үйлчилгээ (1440хүн/цаг, томилолт, замын зардал)			53,584,000	53,584,000
46	Бусад			24,180,800	24,180,800
	НИЙТ ДҮН				200,000,000

ЗӨВШӨӨРСӨН:

МХ-ИЙН ДАРГА, ЕРӨНХИЙ МЕХАНИКЧ Б.ЧИНЗОРИГ

ХЯНАСАН:

ГХЭ-ИЙН ДАРГА М.ДАМДИНСҮРЭН

БОЛОВСРУУЛСАН:

ГХЭ-ИЙН МЕХАНИКЧ Х.ЭРДЭНЭБИЛЭГ